



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/143

Номгон

Аймгийн Онцгой комиссын “Төв штаб”-ыг
шуурхай бүлгийн бүтэц, бүрэлдэхүүнд
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 зүйлийн 27¹.1.4, 27¹.1.6, 28 дугаар зүйлийн 28.1.5, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3, 32.1.5, 32.1.8, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 58 дугаар тушаалаар батлагдсан “Улсын Онцгой комиссын нэгдсэн шуурхай штабын ажиллах журам”-ын 1 бүлгийн 1.3, Улсын Онцгой комиссын даргын 2022 оны 03 дугаар тушаал, Шуурхай штабын даргын 2022 оны 319 дүгээр чиглэл, аймгийн Засаг даргын 2022 оны 35 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабыг оператив бүлгийн зохион байгуулалтад шилжүүлсэнтэй холбогдуулан аймгийн Онцгой комиссын “Төв штаб”-ын үйл ажиллагааг оператив бүлгийн бүтэц, бүрэлдэхүүний хэлбэрт шилжүүлж, үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Онцгой комиссын “Төв штаб”-ын “Хүний гоц халдварт өвчний үед ажиллах шуурхай бүлэг”-ийн даргаар Эрүүл мэндийн газрын дарга (Н.Энхжаргал)-ыг, “Мал, амьтны гоц халдварт өвчний үед ажиллах шуурхай бүлэг”-ийн даргаар Мал эмнэлгийн газрын дарга (Л.Оюун-Эрдэнэ) нарыг тус тус томилж, байгууллага тус бүрд 24 цагийн оператив жижүүрлэлтийн бүлгийг гаргаж, халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулсугай.


3. Аймгийн Онцгой комиссын “Хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх шуурхай ажлын хэсэг”-ийн гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, нэгдсэн удирдлага зохицуулалтад оруулж ажиллахыг шуурхай ажлын хэсгийн дарга (Аймгийн Онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Э.Батбаяр)-д үүрэг болгосугай.

601220345

2.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын удирдлага, зохион байгуулалт хариуцсан орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын
17-ны өдрийн А/143 дугаар захирамжийн
1-р хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ТӨВ ШУУРХАЙ ШТАБЫН ШУУРХАЙ БҮЛЭГТ
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ БҮРЭЛДЭХҮҮН

1. Нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах:

1.1 Аймгийн Онцгой комиссын Э.Батбаяр Аймгийн Онцгой комиссын
“Хүн, мал, амьтны гоц Нарийн бичгийн дарга, дэд
халдварт өвчинтэй тэмцэх хурандаа
шуурхай ажлын хэсэг”-ийн
дарга

2. Хүний гоц халдварт өвчний үед ажиллах шуурхай бүлэг

2.1 Оператив жижүүрлэлтийн Н.Энхжаргал Эрүүл мэндийн газрын дарга
24 цагийн шуурхай бүлгийн
дарга,
2.2 Тохиолдлын нөхцөл С.Батцэцэг Эрүүл мэндийн газрын
байдал хариуцсан Хяналт, шинжилгээ үнэлгээ,
ажилтан: мэдээллийн хэлтсийн дарга
Сургалт, сурталчилгаа, А.Ууганцэцэг Эрүүл мэндийн газрын
урьдчилан сэргийлэх Нийгмийн эрүүл мэндийн
асуудал хариуцсан төвийн Эрүүл мэндийн
2.3 ажилтан: мэдээлэл, сургалт,
сурталчилгаа, эрүүл мэндийг
дэмжих асуудал хариуцсан
мэргэжилтэн
2.4 Мэдээ, мэдээлэл Б.Болормаа Эрүүл мэндийн газрын
хариуцсан ажилтан: Мэдээ, мэдээллийн бааз
хариуцсан ажилтан

3. Мал, амьтны гоц халдварт өвчний үед ажиллах шуурхай бүлэг

3.1 Оператив жижүүрлэлтийн Л.Оюун-Эрдэнэ Мал эмнэлгийн газрын дарга
24 цагийн шуурхай бүлгийн
дарга
3.2 Тохиолдлын нөхцөл Г.Өлзийнаран Мал эмнэлгийн газрын
байдал хариуцсан ажилтан Мал эмнэлгийн улсын ахлах
байцаагч
3.3 Сургалт сурталчилгаа, Ү.Цэндсүрэн Мал эмнэлгийн газрын
урьдчилан сэргийлэх Архив, бичиг хэргийн эрхлэгч
асуудал хариуцсан ажилтан
3.4 Мэдээ, мэдээлэл Б.Дэлгэрдалай Мал эмнэлгийн газрын
хариуцсан ажилтан Мэдээ, тайлан хариуцсан
мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 17-ны
өдрийн А/143 дугаар захирамжийн 2-р хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ТӨВ ШУУРХАЙ ШТАБЫН ШУУРХАЙ БҮЛГИЙН БҮТЭЦ

ТӨВ ШТАБЫН УДИРДЛАГЫН БАЙРНЫ ДАРГА, ШУУРХАЙ
АЖЛЫН ХЭСЭГ ХАРИУЦСАН ОРЛОГЧ ДАРГА,
Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа
Э.Батбаяр (88114512)

Оператив жижүүрлэлтийн 24 цагийн шуурхай
бүлгийн дарга, Эрүүл мэндийн газрын дарга
Н.Энхжаргал (99442181)

Оператив жижүүрлэлтийн 24 цагийн шуурхай
бүлгийн дарга, Мал эмнэлгийн газрын дарга
Л.Оюун-Эрдэнэ (88068898)

Тохиолдлын нөхцөл байдал
хариуцсан ажилтан:
С.Батцэцэг (89895509)

Сургалт сурталчилгаа, урьдчилан
сэргийлэх асуудал хариуцсан ажилтан:
А.Ууганцэцэг (95119240)

Тохиолдлын нөхцөл байдал
хариуцсан ажилтан:
Г.Өлзийнаран (88558589)

Сургалт сурталчилгаа,
урьдчилан сэргийлэх асуудал
хариуцсан ажилтан:
Ү.Цэндсүрэн (89991475)

Мэдээ, мэдээлэл хариуцсан ажилтан:
Б.Болормаа (99045895)

Мэдээ, мэдээлэл хариуцсан ажилтан:
Б.Дэлгэрдалай (88245399)

Шуурхай бүлгийн утас:
Утас: 70440006, 70448268

Шуурхай бүлгийн утас:
Утас: 70442351